

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА



2011 ОНЫ 6 САР

МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Танилцсан:

Ерөнхийлөгч

Л.Пүрэвдорж

Хянасан:

МБСГ-ын захирал

Д.Болдбаатар

МБСГ-ны СХ-ийн захирал

Н.Амар

Боловсруулсан:

СХ-ийн эдийн засагч

С.Билгүүн


СХ-ийн эдийн засагч

Д.Энхзаяа

ТОВЧ ҮР ДҮН

- Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2011 оны 6-р сард Улаанбаатар хотын 1,058 иргэд, 413 ААН болон 9 шинжээчдийг хамруулан явууллаа;
- Иргэд 2011 оны эцэст инфляцийг **12.0%**¹-д хүрнэ гэж үзэж байгаа бол ААН, байгууллагууд инфляцийг **10.6%**-тай байхаар хүлээж байна. Харин 2012 оны 2-р улирлын эцэст буюу 12 сарын дараах иргэдийн хүлээж буй инфляци **12.3%**, ААН, байгууллагуудынх **10.3%**-тай байна.
- Шинжээчид инфляцийг 2011 оны эцэст **9.1%**, 2012 оны 2-р улиралд **10.1%**-д хүрнэ гэж таамаглаж байна.
- Инфляцийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2011 оны 2-р улиралд иргэдийн дунд үнийн түвшин хурдацтай өснө гэсэн хүлээлт өмнөх судалгааны үр дүнгүүдээс нэмэгдсэн нь харагдлаа. Энэ нь иргэдийн дунд үнийн түвшин хурдацтай өснө гэсэн хүлээлт нэмэгдэж байгааг илтгэж байна.

Зураг 1 Иргэд, ААН-ийн хүлээгдэж буй инфляци болон судлаачдын инфляцийн дундаж таамаглал



Сүүдэртсэн хэсэг: иргэд, ААН-ийн хүлээгдэж буй инфляцийн түвшин болон судлаачдын инфляцийн дундаж таамаглалыг илтгэнэ

- Түүвэр судалгааны үр дүнд иргэдийн дийлэнх нь зээлийн хүүний түвшин өндөр хэвээр байгаа бөгөөд хадгаламжинд мөнгөө байршуулахад хараахан тохиромжтой үе биш хэмээн үзсээр байна. Мөн төгрөгийн бусад валюттай харьцах нэрлэсэн ханш чангарна гэж үзэж буй иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.
- ААН, байгууллагуудын дийлэнх нь 2011 оны эхний хагас жилд бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь эрэлт бага зэрэг өссөн гэж үзжээ. Харин ирэх хагас жилд тэдгээрийн тал хувь нь эрэлт нэмэгдэнэ гэж хүлээж байна. Түүнчлэн ААН-үүдийн ихэнх нь ирэх хагас жилд ажилчдын тоондоо өөрчлөлт оруулж, цалингийн түвшингээ өсгөх төлөвлөгөөгүй байна.
- Шинжээчид 2011 оны сүүлийн хагас жилд эдийн засаг өсч, сарын дундаж нэрлэсэн цалин тасралтгүй нэмэгдэнэ гэж үзжээ. Мөн мөнгөний нийлүүлэлт ирэх онд аажмаар өсөх бөгөөд төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш тогтмол чангарах бол юаньтай харьцах нэрлэсэн ханш харьцангуй тогтвортой байхаар таамаглаж байна.

¹ 3 сар болон 12 сарын дараах иргэдийн инфляцийн хүлээлтийн дундаж утгаар төлөөлүүлэн авлаа.


1. ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1,058 иргэдийг санамсаргүйгээр сонгож хамрууллаа. Судалгааны үр дүнгээр иргэдийн инфляцийг 2011 оны 3-р улирлын эцэст 12.3%, 2012 оны 2-р улиралд 11.6%-д хүрнэ гэж хүлээж байна.

1.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Насны бүтцийг харвал судалгаанд оролцогчдын 55.6% нь 25-54 насны;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 86.0% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 85.1% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 59.6% нь хувийн салбарт ажилладаг, 16.8% нь төрийн албанд, 16.0% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 50.7% нь 400 мянгаас доош төгрөгийн орлоготой бөгөөд үүний бараг тал нь 200 мянгаас бага, 40.8% нь 400-800 мянга, 8.5% нь 800 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.¹

Зураг 1.1 Чиглэлийн индекс



Санамж: Уг индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл руу хүлээлт өссөн, хасах чиглэл руу инфляцийн хүлээлт буурсан байгааг илтгэнэ.²

1.2. Чиглэлийн индекс

Иргэдийн 12 сарын дараах үнийн өсөлтийн хүлээлтийг тандсан чанарын хариултаар **Хүлээлтийн чиглэлийн индекс**³-ийг тооцлоо /Зураг 1.1/. Чиглэлийн индекс 2011 оны 1 болон 6 саруудад улаан муж руу нэвтэрсэн нь тухайн хугацаанд иргэд 12 сарын дараа үнийн түвшин **хурдацтай өснө** гэж хүлээж байсныг илтгэж байна. Харин судалгааг явуулсан бусад хугацаанд индекс шар мужид утгаа авч байсан нь иргэд үнийн түвшин **тогтвортой, аажмаар өснө** гэж хүлээж байсныг харуулна.

2011 оны 2-р улиралд явуулсан хүлээлтийн чиглэлийн индекс бусад үеүдээс харьцангуй өндөр түвшинд буюу иргэд үнэ хурдацтай өснө гэсэн хүлээлтийг үүсгэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байх талтай юм. Үүнд:


- Улаанбаатар хотын 2011 оны 6-р сарын ХҮИ-ийн Тээврийн бүлгийн үнэ өмнөх сараас 12.8%-иар, Орон сууцны халуун усны үнэ 50.1%-иар өссөн,
- Иргэдийн дунд Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож байгаа нь эрэлтийг

¹ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.


² Индекс (-1;0) завсарт утгаа авах нь иргэд үнийн түвшин буурна, 0 түвшинд утгаа авах нь үнэ өөрчлөгдөхгүй гэсэн хүлээлттэй байгааг илтгэнэ. Харин индекс (0;1) завсарт үнэ хурдацтай өсөхгүй, (1;2) завсарт үнэ тогтвортой өснө, (2;3) завсарт үнэ хурдацтай өснө гэсэн иргэдийн хүлээлтийг илтгэнэ.

³ Hannah Nielsen /2003/: Inflation Expectations in the EU – Results from Survey data, pp. 10-11

Зураг 1.2 Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?



Зураг 1.3 Ирэх 3 сарын хугацаанд бараа, бүтээгдэхүүний үнэ одоогийнхтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдөх вэ?



өдөөх замаар үнийг хөөрөгдөхүй гэсэн болгоомжлол оршсоор байгаа,

- Бусад улс орнуудад хийгдсэн инфляцийн хүлээлтийн судалгааны үр дүнд Хямралын дараа үеийн тодорхой хугацаанд иргэдийн үнийн өсөлтийн хүлээлт өндөр байдаг гэсэн үр дүн гарсан байдаг.

1.3. Хүлээлтийн түвшин /чанарын хариулт/

2011 оны 2-р улиралд явуулсан судалгаагаар нийт иргэдийн **82%** нь ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин **ерөнхийдөө өснө** гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм /Зураг 1.2/.

Үүнээс иргэдийн 42% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 29% нь одоогийнхтой ижил түвшинд, 11% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэжээ.

Харин судалгаанд оролцогчдын 4% нь үнэ өөрчлөгдөхгүй, 2% нь буурна гэж үзэж байна. Иргэдийн 11% мэдэхгүй гэж хариуллаа.

Түүнчлэн иргэдийн 84% нь ирэх 3 сарын хугацаанд үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад мөн л хамгийн өндөр түвшинд хүрлээ /Зураг 1.3/.


Үүнээс 43% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 30% нь одоогийнхтой адил түвшинд, 11% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэж үзжээ. Харин 5% нь үнэ өөрчлөгдөхгүй, 1.7% нь буурна гэж үзэж байна

Дээрх чанарын хариултуудыг Карлсон-Паркин нарын магадлалын аргаар⁴ тоон утгад хөрвүүлэн тооцвол иргэд 2011 оны 3-р улирлын эцэст жилийн инфляци **12.3%**, мөн оны эцэст жилийн инфляци **12.0%**, 2012 оны 2-р улирлын эцэст **11.6%**-д хүрнэ гэж хүлээж байна.

Зураг 1.4-өөс харахад 1 сараас хойших иргэдийн жилийн инфляцийн хүлээлт тухайн

⁴ Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Economica" 42, pp. 123-38. Энэ удаагийн судалгаанаас эхлэн Карлсон-Паркин нарын хүлээгдэж буй инфляцийг тооцох тооцоололд өнөөдрийн инфляциар өмнөх 12 сарын дундаж жилийн инфляцийн түвшинг ашиглаллаа.

Зураг 1.4 Жилийн инфляцийн хүлээлт ба инфляцийн түвшин



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

үеийн инфляцийн түвшнээс үргэлж дээгүүр буюу жилийн дараа тухайн үеийнхээс илүү өндөр инфляцитай байна гэж хүлээж байна. 2011 оны 1-р сард хүлээлт болон тухайн үеийн инфляцийн хоорондын зөрүү хамгийн их байсан бол 3 болон 6-р саруудад бага зэрэг ойртож, иргэдийн хүлээлт тогтворжих хандлага ажиглагдаж байна.


Шигтгээ 1.1. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 6 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 2.8%, оны эхнээс 7.2%, өмнөх оны мөн үеийнхээс 5.5%-иар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний үнийн ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2.5%, тээврийн бүлгийнх 12.8%-иар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Согтууруулах ундаа, тамхи, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ болон боловсролын бүлгийн дүнгээр үнэ тогтвортой, эдгээрээс бусад бүлгийн үнэ 1.3-2.9%-иар өссөн байна.

Харин өмнөх оны мөн үеийнхээс өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 15.3%, тээврийн бүлгийн үнэ 15.1%, орон сууц, ус, түлш, цахилгааны бүлгийн үнэ 13.6%, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 20.4%-иар өссөн нь голчлон нөлөөлсөн бол хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.0%-иар буурч ерөнхий хэрэглээний үнийн индексийн өсөлтийг сааруулсан байна.

Зураг 1.5 Хүлээлтийн түвшин, тоон хариулт /ирэх 12 сарын хугацаанд/




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа 2011 оны 6 сар

1.4. Хүлээлтийн түвшин /тоон хариулт/

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. Зураг 1.5-аас харахад судалгаанд оролцсон иргэдийн 27% нь инфляцийг 12 сарын дараа 13-15%-д, 18% нь 11-13%-д, мөн 17% нь 9-11%-д байна гэж үзжээ. Иргэдийн инфляцийн хүлээж буй утга **12.6%** байна /Зураг 1.4/.

Зураг 1.6 Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.5. Бусад асуултуудын дүн

Судалгаанд оролцсон иргэдийн зээлийн хүү өснө гэж хариулсан хувь 2008 оны 12 сараас тогтвортой буурч байсан ч 2011 оны 3 сарын түүвэр судалгаанаас эхлэн буцаад өсөх хандлагатай болжээ. 2011 оны 6 сард судалгаанд оролцогчдын 24% нь зээлийн хүү өснө гэж үзжээ /Зураг 1.6/.


Харин зээлийн хүү хэвэндээ байна гэсэн дүн 32%-д хүрч 2011 оны 1 болон 7 сарын судалгааны дүнтэй ижил түвшинд хүрсэн байна. Зээлийн хүү буурна гэж иргэдийн 24% нь хариулсан нь өмнөх судалгааны дүнгүүдээс өсч хамгийн өндөр түвшинд хүрчээ. Зээлийн хүүгийн түвшин буурна гэсэн иргэдийн хүлээлт ийнхүү нэмэгдэхэд Монголбанкны зүгээс Зээлийн хүүг бууруулах зах зээлийн таатай орчинг бүрдүүлэх ажлыг шат дараатай авч хэрэгжүүлж байгаа болон инфляцийн түвшин буурч, 2010 оны эхнээс нэг оронтой тоонд байгаа нь голлон нөлөөлсөн байх талтай юм.

Зураг 1.7 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?




Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 1.8 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 1.9 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Төгрөгийн бусад валюттай харьцах ханшийг чангарна гэж үзсэн иргэдийн хувь 2011 оны эхнээс буурч, суларна гэж үзсэн иргэдийн хувь өсөх хандлагатай байна. 2011 оны 6-р сарын дундаж ханш өмнөх сартай харьцуулахад 1.7%-иар суларсан бол өмнөх оны мөн үеэс 8.9%-иар чангарсан байна /Зураг 1.7/.


Судалгаанд оролцогчдын 20 гаруй хувь нь хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнгүүдтэй харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Харин тохиромжгүй гэсэн хариулт эргэн өсч 30 гаруй хувьд хүрээд байна. 2011 оны 6-р сарын эцсийн байдлаар хадгаламжийн бодит хүү эерэг⁵ байгаа бөгөөд төгрөгийн хадгаламж өсөх⁶ хандлага үргэлжилсээр байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан иргэдийн хадгаламж хийхэд тохиромжгүй үе гэсэн хариултын хувь эргэн өсөх хандлага ажиглагдлаа /Зураг 1.8/.

Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцогчдын 30% үзсэн нь өмнөх судалгааны дүнгүүдээс өсч хамгийн өндөр түвшиндээ хүрлээ. Гэсэн хэдий ч муудна гэж үзсэн иргэдийн хувь эргэн өсч 18%-д хүрсэн бол хэвэндээ байна гэсэн нь өмнөх судалгааны дүнгүүдтэй ойролцоо түвшинд гарлаа.

⁵ 2011 оны 6 сарын эцсийн байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү 4.8% байна.


⁶ 2011 оны 6 сарын эцсийн байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 74.2 хувийн өсөлттэй байна.

Зураг 1.10 Сайжрах бол шалтгаан нь юу вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 1.11 Муудах бол шалтгаан нь юу вэ?



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Өрхийн санхүүгийн байдал **сайжирна** гэж судалгаанд оролцсон иргэдийн 30% нь хариулсан бөгөөд иргэдийн 14.9% нь ирэх 12 сард цалин нэмэгдэнэ, 15.2% нь татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртэнэ, 14.5% нь хамаатан найз нараас тусламж авна гэсэн хариултыг өгсөн байна. Харин үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө, бизнесийн орлого нэмэгдэнэ, үнэ буурна гэсэн хариултуудын хувь хэмжээ харьцангуй бага байна.

Өрхийн санхүүгийн байдал **муудна** гэж иргэдийн 18% нь хариулсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь ирэх 12 сарын хугацаанд цалин буурна, өрхийн гишүүн ажилгүй болно, татварын ачаалал ихэснэ, үнэ өснө гэсэн хариултуудыг өгсөн байна. Харин бизнесийн орлого буурна, төрөөс тэтгэмж, тэтгэлэг авахгүй гэсэн хариултуудын хувь хэмжээ харьцангуй бага байна.

ДҮГНЭЛТ

Санал асуулгын дүнгээр иргэдийн дийлэнх хувь нь ирэх нэг жилийн хугацаанд үнийн түвшинг ерөнхийдөө өснө гэж хүлээж байгаа бөгөөд харин ердөө 2% нь буурна гэж үзжээ. Эдгээр чанарын хариултуудыг тоон утгад хөрвүүлбэл жилийн дараах иргэдийн хүлээлт 12.3%-д хүрч, өнөөдрийн инфляцийн түвшингээс өснө гэж үзжээ.

Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индексийг тооцож харахад 2011 оны эхнээс иргэдийн хүлээлт огцом нэмэгдэж 6 сарын байдлаар хамгийн өндөр түвшиндээ хүрээд байна.

Бусад асуултуудын дүнгээр иргэдийн ихэнх нь ирэх 12 сард зээлийн хүү өсөх эсвэл хэвэндээ байна, хадгаламжинд мөнгөө байршуулахад хараахан тохиромжтой үе биш хэмээн үзсэн хэвээр байгаа бол төгрөгийн ханш суларна гэсэн хариултын хувь өсөх хандлагатай байна. Харин тэдний өрхийн санхүүгийн байдлын талаар асуухад муудна гэсэн хариултын хувь өсөх хандлагатай болсон хэдий ч сайжирна, хэвэндээ байна гэж үзсэн иргэдийн хувь хэмжээ зонхилох хувийг эзэлсэн хэвээр байна.

2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан инфляцийн хүлээлтийн талаарх түүвэр судалгааг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 413 аж ахуйн нэгжийг хамруулан судаллаа. Судалгааны үр дүнгээс харахад ААН, байгууллагууд 2011 оны эцэст инфляцийг 10.9%, 2012 оны хагас жилийн эцэст 10.3%-д хүрнэ гэж хүлээж байна. Өөрөөр хэлбэл ААН-үүдийн дунд 2011 оны эцэст инфляцийн түвшин өнөөдрийн түвшингээс өснө гэж үзжээ.

Хүснэгт 2.1 Аж ахуйн нэгж
/өмчлөлөөр/

Аж ахуй нэгжийн хэлбэр	тоо	хувь
Нөхөрлөл	16	3.9
Хоршоо	18	4.4
Хувьцаат компани	23	5.6
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	353	85.5
Төрийн өмчийн үйлдвэрийн газар	1	0.2
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	2	0.5
Нийт дүн	413	100.0

2.1. Түүвэр судалгаанд оролцогчид

Судалгаанд хамрагдсан нийт 413 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 85.5% нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 5.6% нь хувьцаат компани байлаа /Хүснэгт 2.1/.

Хүснэгт 2.2 ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ
/салбараар/

Салбарын бүлэг	тоо	хувь
Хөдөө аж ахуй	12	2.9
Уул уурхай, олборлох	6	1.5
Боловсруулах үйлдвэр	4	1.0
Барилга	28	6.8
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	116	28.1
Жижиг, дунд үйлдвэрлэл	38	9.2
Зоогийн газар, зочид буудал	86	20.8
Тээвэр	12	2.9
Бусад үйлчилгээ	111	26.9
Нийт дүн	413	100.0

Түүвэр судалгаанд бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 116 (28.1%), зоогийн газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 86 (20.8%), барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 40 (10.2%), болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 122 (31.1%) ААН-ийг хамрууллаа /Хүснэгт 2.2/.

Хүснэгт 2.3 ААН-ийн салбарын бүлэг
/ажилчдын тоогоор/

Салбарын бүлэг	Ажилчдын тоо /бүлгээр/				
	< 10	11-50	51-100	101 <	Бүгд
Хөдөө аж ахуй	5	6	1	0	12
Уул уурхай, олборлох	4	1	1	0	6
Боловсруулах үйлдвэр	1	2	0	1	4
Барилга	9	14	3	2	28
Б/Ж-ийн худалдаа	97	15	3	1	116
Жижиг, дунд үйлдвэрлэл	21	14	2	1	38
Зоогийн газар, зочид буудал	72	12	2	0	86
Тээвэр	8	3	0	1	12
Бусад үйлчилгээ	84	22	4	1	111
Нийт дүн	301	89	16	7	413

Түүвэр судалгаанд хамрагдсан ААН-үүдийг ажилчдын бүлгээр авч үзвэл 10 болон түүнээс бага ажилчинтай¹ 301 (72.9 %), 11-ээс 50 хүртэлх ажилчинтай 89 (21.5%), 51-ээс 100 хүртэлх ажилчинтай 16 (3.9%), болон 100-аас дээш ажилчинтай 7 (1.7%) байгууллагууд хамрагдлаа /Хүснэгт 2.3/.


¹ Тогтмол хөдөлмөр эрхэлдэг ажилчинтай

Хүснэгт 2.4 ААН-ийн хүлээгдэж буй үнийн ерөнхий түвшин

№	Хариултын төрөл	Үнийн хүтээлт		
		2011 III улирал	2011 IV улирал	2012 II улирал
1	Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	37.2%	32.0%	36.7%
2	Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	31.1%	38.1%	26.4%
3	Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай буурна	6.6%	6.1%	8.0%
4	Үнэ өөрчлөгдөхгүй	12.5%	7.5%	7.5%
5	Үнэ буурна	0.2%	1.2%	1.2%
6	Мэдэхгүй	12.5%	15.1%	20.2%
	Нийт	301	89	16


Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 2.1 ААН-ийн үнийн ерөнхий түвшний хүлээлт



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 2.2 ААН-ийн 12 сарын дараах үнийн өсөлтийн түвшин /харьцангуй давтамж/



Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

2.2. Үнийн ерөнхий түвшний хүлээлт

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан 2011 оны 6-р сарын инфляцийн хүлээлтийн санал асуулгыг явуулахдаа чанарын болон тоон хариултыг авах замаар 2 аргачлалаар хүлээлтийг тооцсон болно.

Үнийн ерөнхий түвшин /чанарын хариулт/

Аж ахуйн нэгж, байгууллагын үнийн ерөнхий түвшний хүлээлтийг тандахдаа тэдгээрээс ирээдүйн үнийн түвшний таамаглалыг одоогийн түвшинтэй харьцуулсан чанарын хариултыг авах замаар тооцсон /Хүснэгт 2.4/.

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны үндсэн асуулт болох “*Танай компанийн түүхий эд болон бусад бараа материалд төлж байгаа үнэ 2011 оны 3, 4 болон 2012 оны 2-р улирлуудад хэрхэн өөрчлөгдөнө гэж та үзэж байна вэ?*” гэсэн асуултад судалгаанд оролцсон ААН, байгууллагуудын 74.8%, 76.2% болон 71.1% нь харгалзах улирлуудад үнийн түвшин ерөнхийдөө өснө гэсэн хариултуудыг өгчээ. Харин 12.5% нь 2011 оны 3-р улиралд үнэ өөрчлөгдөхгүй гэж үзсэн бол 4-р улирал болон 2012 оны 2-р улиралд 7.5% нь энэхүү хариултыг өгчээ. Үнэ буурна гэсэн хариултын түвшин маш бага байна /Зураг 2.1/.

Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлал (Carlson-Parkin method)-аар тоон үзүүлэлт рүү шилжүүлэн тооцоход ААН, байгууллагын түүхий эд болон бусад бараа материал, үйлчилгээнд төлж байгаа инфляцийн түвшин 2011 оны 3, 4 болон 2012 оны 2-р улирлын эцэст харгалзан **10.9%, 10.6%, 10.3%-тай** байхаар хүлээгдэж байна. Өөрөөр хэлбэл, түүвэр судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд инфляцийн түвшин өнөөдрийн түвшингээс өснө гэж үзжээ.

Үнийн ерөнхий түвшин /тоон хариулт/

Судалгаанд оролцсон ААН, байгууллагын 12 сарын дараах инфляцийн хүлээлтийн түвшинг тодорхой тоон утгаас асуухад **12.2%**-тай байна /Зураг 2.2/.

Хүснэгт 2.5 ААН-ийн өнгөрсөн 6 сар дахь эрэлт /бараа бүтээгдэхүүн/

Хариулт	2011 оны 1 сар	2011 оны 6 сар	Өөрчлөлт
Өссөн	40.6	36.8	-3.8
Өөрчлөгдөөгүй	46.2	48.2	2.0
Буурсан	13.2	15.0	1.8
Нийт дүн	100	100	

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хүснэгт 2.6 ААН-ийн ирэх 6 сарын эрэлт

Хариулт	2011 оны 1 сар	2011 оны 6 сар	Өөрчлөлт
Өснө	46.9	43.1	-3.8
Өөрчлөгдөхгүй	24.5	28.3	3.8
Буурна	9.7	8.5	-1.2
Мэдэхгүй	18.9	20.1	1.2
Нийт дүн	100	100	

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хүснэгт 2.7 ААН-ийн ажлын байр, цалингийн өсөлт

Ирэх 6 сард ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ирэх 6 сард цалингаа өсгөх үү?		
	Тийм	Үгүй	Нийт дүн
Нэмэгдэнэ	17.7	12.6	30.3
Өөрчлөгдөхгүй	18.6	45.5	64.2
Буурна	2.7	2.9	5.6
Нийт дүн	39.0	61.0	100.0

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

2.3. Бусад хариулт

Бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт


Судалгаанд оролцсон байгууллагуудаас бүтээгдэхүүн болон үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар асуухад санал асуулгад оролцогчдын 36.8% нь өссөн, 48.2% нь өөрчлөгдөөгүй, 15.0% нь буурсан гэж хариулсан нь 2011 оны 1-р сард явуулсан санал асуулгын дүнтэй харьцуулахад эрэлт өссөн гэсэн хариултын хувь 3.8 нэгж хувиар буурч, харин буурсан гэсэн хариулт 1.8 нэгж хувиар өссөн нь иргэдийн худалдан авалт бага зэрэг буурсан гэж үзэхээр байна /Хүснэгт 2.5/.

ААН, байгууллагуудаас ирэх 6 сарын хугацаанд бараа болон бүтээгдэхүүний хүлээгдэж буй эрэлтийн түвшний талаар асуухад 43.1% нь өснө, 28.3% нь өөрчлөгдөхгүй, 8.5% нь буурна гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эрэлт өснө гэсэн хариултын хувь 3.8 нэгжээр, буурна гэж хариулсан хувь 1.2 нэгжээр мөн буурсан байна /Хүснэгт 2.6/.

Ажил эрхлэлт, цалин

Судалгаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудаас “Ирэх 6 сард танай компанийн ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэсэн асуулт тавихад санал асуулгад оролцогчдын 125 нь буюу 30.3% нь нэмэгдэнэ гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 12.8 нэгж хувиар буурчээ.

Түүнчлэн ажлын тоогоо нэмэгдүүлж, ирэх 6 сард цалингаа нэмэгдүүлэхээр төлөвлөж буй нийт 73 (17.7%) аж ахуйн нэгж байна. Харин ажилчдын тоондоо өөрчлөлт оруулахгүйгээр цалингаа нэмэгдүүлэх 77 (18.6%), цалингаа өсгөхгүй байх 252 (61.0%) аж ахуйн нэгж байна /Хүснэгт 2.7/.

Зураг 2.3 ААН-ийн цалингийн өсөлт /хувиар/

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хүснэгт 2.8 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр

Санхүүжилтийн хэлбэр	2011 оны 1 сар	2011 оны 6 сар	Өөрчлөлт
Банкны санхүүжилтээр	40.7	46.1	5.4
Компанийн өөрийн хөрөнгөөр	40.3	43.3	3.0
Хувьцаа гаргах	4.1	2.3	-1.8
Гадаад эх үүсвэр	9.5	3.7	-5.8
Санхүүгийн байгууллагын эх үүсвэр	4.1	3.2	-0.9
Тэтгэлэг тусламжаар	1.2	1.4	0.2
Нийт дүн	100	100	

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хүснэгт 2.9 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр /ажилчдын тоогоор/

Санхүүжилтийн хэлбэр	Ажилчдын тоо				Бүгд
	1-10	11-50	51-100	100-аас их	
Банкны санхүүжилтээр	32.7	11.1	1.4	0.9	46.1
Компанийн өөрийн хөрөнгөөр	28.1	11.5	2.8	0.9	43.3
Хувьцаа гаргах	1.8	0.5	0.0	0.0	2.3
Гадаад эх үүсвэр	2.8	0.9	0.0	0.0	3.7
Санхүүгийн байгууллагын эх үүсвэр	2.3	0.0	0.5	0.5	3.2
Тэтгэлэг тусламжаар	1.4	0.0	0.0	0.0	1.4
Нийт дүн	69.1	24.0	4.6	2.3	100.0

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Цалингийн түвшингээ ирэх 6 сард нэмэгдүүлнэ гэж хариулсан ААН-ээс цалингийн түвшингээ хэд хүртэл хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгааг нь тодруулахад 55.0% нь 10 хүртэл хувь, 44.0% нь 11-30 хүртэл хувиар, үлдсэн 1.0% нь 30-аас дээш хувиар өсгөхөөр төлөвлөж байна /Зураг 2.3/.

Түүвэр судалгааны санал асуулгын үр дүнгээс харахад ойрын хугацаанд шинэ ажлын байр нэмэгдэх магадлал бага байгаа бөгөөд, дийлэнх ААН ирэх 6 сард ажилчдын цалингаа нэмэгдүүлэхгүй гэжээ.

Санхүүжилт болон зээл

Санал асуулгад оролцсон ААН, байгууллагуудаас “Ирэх 6 сарын хугацаанд компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна уу?” гэж асуухад 52.5% нь тийм, 47.5% нь үгүй гэж хариуллаа. Энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад тийм гэсэн хариулт 9.5 нэгж хувиар буурсан байна /Хүснэгт 2.8/.

Өргөжүүлэх төлөвлөгөөтэй дээрх ААН, байгууллагуудаас ямар эх үүсвэрээр компаниа өргөжүүлэх талаар асуухад 46.1% нь банкны зээл, 43.3% нь компанийн өөрийн хөрөнгөөр санхүүжнэ гэсэн бол гадаад эх үүсвэр, хувьцаа гаргах, бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр, тэтгэлэг тусламжаар санхүүжих ААН-үүд 1.4%-3.7% хооронд байна.

Түүнчлэн бичил бизнес² эрхлэгчдийн 69.1% нь банкны санхүүжилтээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бол жижиг дунд бизнес³ эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 24%-тай байна /Хүснэгт 2.9/. Эндээс дүгнэхэд бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь тодорхой хэмжээний банкны зээлийн хэрэгцээ шаардлагатай байгаа нь түүвэр судалгааны үр дүнгээс харагдлаа.

Аж ахуйн нэгжээс “Ирэх 6 сард танай компанийн зээлийн хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэж асуухад 35.8% нь нэмэгдэнэ, 57.6% нь өөрчлөгдөхгүй, харин 6.5% нь буурна гэж хариулсан байна. Үүнийг өмнөх судалгааны

² Үндсэн ажилчдын тоо 10-аас бага

³ Үндсэн ажилчдын тоо 11-50 хүртэлх

Хүснэгт 2.10 ААН-ийн ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ

Хариулт	2011 оны 1 сар	2011 оны 6 сар	Өөрчлөлт
Нэмэгдэнэ	42.6	35.8	-6.8
Өөрчлөгдөхгүй	52.3	57.6	5.3
Буурна	5.4	6.5	1.1
Нийт дүн	100	100	

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

үр дүнтэй харьцуулахад зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ гэж хариулсан аж ахуйн нэгжийн тоо даруй 6.8 нэгж хувиар буурчээ.

ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН, байгууллагууд инфляцийн түвшинг 2011 оны эцэст **10.6%**, 2012 оны хагас жилийн эцэст 10.3%-д хүрнэ гэж хүлээж байна.


Түүнчлэн ААН, байгууллагуудад ойрын ирээдүйд үйл ажиллагаа явуулах болон өргөжүүлэхэд нь санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байгаа нь түүвэр судалгааны үр дүнгээс харагдлаа. Санхүүжилт шаардлагатай байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь нь банкнаас санхүүжилт авах сонирхолтой байна.

3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР

СУДАЛГААНЫ ДҮН

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн судалгаанд арилжааны банкинд ажилладаг нийт 9 шинжээч оролцов. Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, нийт мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт, цалин)-ийг багтаасан бөгөөд хариултыг шууд тоон үзүүлэлтээр авч, шинжээчдийн таамгуудын жигнэсэн дунджаар хүлээлтийг тооцоолов. Судалгааны дүнгээс харахад шинжээчид жилийн инфляци 2011 оны 3-р улиралд 10.0%, оны эцэст 9.1%, 2012 оны 1-р улиралд 10.1% болохоор таамаглаж байна.

Зураг 3.1 Инфляци




Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.1. Инфляци

Шинжээчдийн таамгаар жилийн инфляци 2011 оны 3-р улиралд 10.0%, оны эцэст 9.1%, 2012 оны 1-р улиралд 10.1% байхаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3-р улирлын инфляцийн хүлээлт 4.6 нэгжээр, оны эцсийнх 6.4 нэгжээр буурсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд жилийн инфляци 16.5%, хамгийн бага хүлээлттэй нь 6.1% байхаар таамаглажээ /Зураг 3.1/.

Зураг 3.2 Нийт мөнгөний өсөлт /M2/




Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.2. Нийт мөнгөний өсөлт /M2/

Шинжээчид M2 мөнгөний өсөлт тасралтгүй өсч, 3-р улиралд 67.6%, оны эцэст 68.1%, 2012 оны 1-р улиралд 71.4%-д хүрнэ гэж тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын хүлээлт харгалзан 19.3 ба 18.3 нэгжээр өссөн байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд M2 мөнгөний жилийн өсөлт 115.7%, хамгийн бага хүлээлттэй нь 30.0% байхаар таамаглажээ /Зураг 3.2/.

Зураг 3.3 Төгрөг/долларын ханш




Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 3-р улиралд 1224.7 төгрөг, оны эцэст 1215.5 төгрөг, 2012 оны 1-р улиралд 1213.7 төгрөг болж тогтмол чангарахаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын таамаг харгалзан 4.5% ба 4.2%-иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1360.2 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 2011 оны эцэст 1042.5 төгрөг байхаар таамаглажээ /Зураг 3.3/.

Зураг 3.4 Төгрөг/юаны ханш




Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.4. Төгрөгийн юаньтай харьцах ханш

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 3-р улиралд 190.6 төгрөг болох бөгөөд 2012 оны 1-р улирал хүртэл харьцангуй тогтвортой байхаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад юаны ханшийн хүлээлт 2011 оны 3 улиралд 3.9%, 4-р улиралд 4.8%-иар өссөн байна. Шинжээчдээс хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 216.3 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 2011 оны эцэст 165.4 төгрөг байхаар таамаглаж байна /Зураг 3.4/.

Зураг 3.5 ДНБ-ий жилийн өсөлт




Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.5. ДНБ-ий жилийн өсөлт

Шинжээчид ДНБ-ий өсөлт 2011 оны 2-р улиралд 8.4%, 3-р улиралд 9.0%, жилийн эцэст 8.9%, 2012 оны 1-р улиралд 10.5% болохоор таамаглаж байгаа нь өмнөх судалгаатай ойролцоо түвшинд байна. Шинжээчдээс хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд ДНБ-ий өсөлт 14.1%, хамгийн бага хүлээлттэй нь 2011 оны 3-р улиралд 0.6% болохоор таамаглажээ /Зураг 3.5/.

Зураг 3.6 Сарын дундаж нэрлэсэн цалин



Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.6. Сарын дундаж нэрлэсэн цалин

Шинжээчдийн таамгаар сарын дундаж нэрлэсэн цалин тогтмол өсч, 2012 оны 1-р улирал гэхэд 450.9 мянган төгрөгт хүрнэ гэж тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 3 ба 4-р улирлын хүлээлт 15.0% ба 17.6%-иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 1-р улиралд сарын дундаж нэрлэсэн цалин 495.0 мянган төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 414.6 мянган төгрөг байхаар таамаглажээ /Зураг 3.6/.

ДҮГНЭЛТ

Шинжээчдийн таамгаас харахад инфляци 2011 оны 3-р улиралд өсөөд, оны эцэст буурч, 2012 оны 1-р улиралд эргээд өсөхөөр хүлээгдэж байна. Харин мөнгөний нийлүүлэлт, ДНБ ба нэрлэсэн цалин 2011 оны 3-р улирлаас 2012 оны 1-р улирал хүртэлх хугацаанд тогтмол өснө гэж таамаглаж байна. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш тогтмол чангарах бол юаньтай харьцах нэрлэсэн ханш харьцангуй тогтвортой байхаар таамаглаж байна.